-Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, соёл, спортын олон талт арга хэмжээг зохион байгуулж улс, тив дэлхийн хэмжээнд хүрэх, урлаг, спортын авьяастнуудыг олноор төрүүлэн гаргаж олон нийтэд гоо зүй, ёс суртахууны хүмүүжлийг төлөвшүүлэх;

-Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой зохион байгуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн амьжиргааны төвшин дээшлүүлэх;

-Гэр бүлийн үнэ цэнэ, тогтвортой байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх;

-Малын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар хүртээмжийг сайжруулах, малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэх, газар тариаланг дэмжих төрөл бүрийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

-Газрын харилцааны салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж хүн амын эрүүл аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх;

-Сумын нутаг дэвсгэрт байгаа Улсын тусгай болон орон нутгийн хамгаалалттай газар, аймаг, сумын байгалийн үзэсгэлэнт газар, түүр соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг сайжруулан орон нутагтаа тохирсон аялал жуулчлалыг хөгжүүлэх;

-Төрийн үйлчилгээг иргэдийн оролцоонд тулгуурласан, ил тод, нээлттэй, хуулийг дээдэлсэн, мэргэшсэн, тогтвортой, хариуцлагатай, төрийн албыг төлөвшүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;
- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль;
- Бусад.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд харьяа орон нутаг дахь төсөвт байгууллага, сангийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Дорноговь аймгийн Санхүү төрийн сангаас боловсруулан гаргасан санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь , холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,229.1 сая төгрөгөөр буюу 59 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	461.77	504.24	42.46
Авлага	299.90	49.02	-250.88
Бараа материал	533.92	136.96	-396.96
Нөөцийн бараа	0	0	0.00
Үндсэн хөрөнгө	9,254.41	3,630.66	-5,623.74
Нийт хөрөнгө	10,550.00	4,320.88	-6,229.12
Өр төлбөр	67.61	11.99	-55.62
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,482.38	4,308.88	-6,173.50
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,550.00	4,320.88	-6,229.12

Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад дансны эцсийн үлдэгдлүүдэд материаллаг өөрчлөлтүүд гарсан бөгөөд улсын төсвийн санхүүжилтийн байгууллага болох эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын төсөв, санхүүгийн тайлан харьяа Төсвийн ерөнхий захирагчдаа шилжиж байгаа нь материаллаг өөрчлөлтүүд гарахад нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 504.2 сая төгрөг болж, өмнөх оноос 42.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	461.77	504.24	-42.94
Төгрөг	461.77	504.24	-42.94
Төрийн сангийн харилцах	460.20	504.24	-42.12
Нэмэлт санхүүжилтийн харилцах	1.57	0	-0.82
Дүн	461.77	504.24	-42.94

Эх сурвалж: Айраг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны өөрчлөлтөд: Сум хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 74.6 сая төгрөгөөр, нөхөн сэргээлтийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12.2 сая төгрөгөөр, ЗДТГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3.3 сая төгрөгөөр нэмэгдэж, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 46.2 сая төгрөгөөр, , нэмэлт дансны төвлөрүүлэлтийн үлдэгдэл болон ахмадын сангийн зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн ба эцсийн үлдэгдэл 504.2 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 49.0 сая төгрөг болж, өмнөх оноос 250.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	0.85	0	-0.85
Зээлийн хүүгийн авлага	0	0	0.00
Байгууллагаас авах авлага	180.02	0	-180.02
Хувь хүмүүсээс авах авлага	1.05	1.16	0.11
Зээлийн авлага	117.97	47.86	-70.11
Дүн	299.90	49.02	-250.88

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Айраг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны өөрчлөлт нь ЗДТГ-ын авлагын үлдэгдэл 3.7 сая төгрөгөөр нэмэгдсэн, ОНХС-ийн авлагын үлдэгдэл 18.0 сая төгрөгөөр, Сум хөгжлийн сангийн авлагын үлдэгдэл 70.0 сая төгрөгөөр, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 166.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэл тус тус буурсантай холбоотой байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 136.9 сая төгрөг болж, өмнөх оноос 201.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	107.68	1.68	-116.13
Тусгай зориулалттай материал	77.12	1.68	-82.93
Эм боох материал	30.56	0	-33.21
Хангамжийн материал	413.42	129.53	-109.93
Бичиг хэргийн материал	7.76	2.74	-2.69
Аж ахуйн материал	21.33	0.18	-81.85
Сэлбэг хэрэгсэл	6.48	0.45	
Түлш, шатах тослох материал	3.04	0	0.38
Барилгын засварын материал	9.58	0	0
Хүнсний материал	6.22	0	-12.45
Бусад хангамжийн материал	359.01	126.16	-13.32
Мал амьтад	12.81	5.74	18.47
Дүн	533.92	136.96	-201.07

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Айраг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны өөрчлөлтөд: сумын ИТХ-ын үлдэгдэл 1.8 сая төгрөгөөр, ЗДТГ-ын үлдэгдэл 16.4 сая төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 219.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэл хасагдсан нь нөлөөлсөн байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,630.7 сая төгрөг болж, өмнөх оноос 5,623.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	9,011.43	3,390.62	-5,620.81
Барилга, байгууламж, орон сууц	6,680.32	2,006.03	-4,674.29
Авто-тээврийн хэрэгсэл	183.45	82.72	-100.73
Машин тоног төхөөрөмж(компьютер)	469.39	106.15	-363.25
Тавилга, аж ахуйн эд хогшил	168.04	33.02	-135.01

/сая төгрөгөөр/

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Бусад үндсэн хөрөнгө	1,354.07	1,132.89	-221.18
Дуусаагүй барилга, байгууламж	62.63	12.90	-49.74
Ном	93.53	16.91	-76.62
Биет бус хөрөнгө	242.98	240.05	-2.93
Программ хангамж	8.61	69.27	60.66
Бусад биет бус хөрөнгө	234.36	170.78	-63.59
Дүн	9,254.41	3,630.66	-5,623.74

Эх сурвалж: Айраг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдлийн өөрчлөлтөд ЗДТГ-ын хөрөнгө 279.1 сая төгрөгөөр, ИТХ-ын хөрөнгө 5.0 сая төгрөгөөр нэмэгдэж, ОНХС-ийн хөрөнгө 49.7 сая төгрөгөөр, ЭМТ, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын 5,858.1 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэл хасагдсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын Засаг даргын тамгын газар - АИТХ-ын 2022.06.24-ний өдрийн 07/04 дүгээр тогтоолоор балансас балансруу шилжүүлэх 93.9 төгрөгийн 2 хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгээгүй алдааг аудитын явцад залруулав.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан - Тайлант оны дуусаагүй ажлын гүйцэтгэл болох 12.3 сая төгрөгийг дуусаагүй барилга дансанд буруу бүртгэсэн алдааг аудитын явцад залруулав.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 12.0 сая төгрөг болж, өмнөх оноос 55.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	67.61	11.99	-55.62
Ажилчидтай холбогдсон өглөг	36.45	0	-36.45
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	0	0.00
Байгууллагад төлөх өглөг	27.62	8.16	-19.46
Хувь хүмүүст төлөх өглөг	3.54	3.83	0.29
Дүн	67.61	11.99	-55.62

Эх сурвалж: Айраг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдлийн өөрчлөлтөд: СХС-ийн өглөг 0.3 сая төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ, сургууль, цэцэрлэгийн 55.9 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл хасагдсан нь нөлөөлсөн байна.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,308.9 сая төгрөг болж, өмнөх оноос 6,173.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,372.04	1,670.18	-1,701.86
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	3,372.04	1,670.18	-1,701.86
Хуримтлагдсан үр дүн	5,757.43	2,167.94	-3,589.49
Өмнөх үеийн үр дүн	4,855.47	8,232.93	3,377.46
Тайлант үеийн үр дүн	901.96	-6,064.99	-6,966.95
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,352.92	470.77	-882.15
Дүн	10,482.38	4,308.88	-6,173.50

Эх сурвалж: Айраг сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдлийн 1,701.9 сая төгрөгийн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдлийн 882.1 сая төгрөгийн бууралтууд нь улсын төсөвт байгууллагуудын оны эхний үлдэгдлийн хасалт байна.

Хуримтлагдсан үр дүнгийн дансны үлдэгдэл 2,167.9 сая төгрөг болж 3,589.5 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 689.5 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5.0 сая төгрөг, нийт зарлагыг 694.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 97.5 сая төгрөгөөр бууруулж, 597.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 05/04 дугаар тогтоолд зааснаар Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 362.2 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан ба үүнийг сумын ИТХ-ын 2021 оны 04/04 дугаар тогтоолоор нэмэгдүүлж 415.8 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор сумын татварын болон татварын бус орлогод тодотгол хийн 75.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 491.5 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 511.8 сая төгрөгийн татварын болон татварын бус орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 20.3 сая төгрөгөөр давуулан 104.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №10. Төвлөрүүлэх орлого

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	Үйл ажиллагааны орлого	25.30	25.31	0.01	100.0%
2	Хадгаламжийн хүүгийн орлого	23.42	24.29	0.88	103.7%
3	Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар	19.49	19.20	-0.29	98.5%
4	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	14.75	15.05	0.30	102.0%
5	Галт зэвсгийн албан татвар	1.36	1.42	0.06	104.4%
6	Малын тоо толгойн албан татвар	48.66	53.71	5.05	110.4%
7	Улсын тэмдэгийн хураамж	2.85	3.27	0.42	114.6%
8	Газрын төлбөр	56.50	57.12	0.62	101.1%
9	Хог хаягдлын хураамж	14.50	14.54	0.04	100.3%
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал	0.58	0.51	-0.07	88.6%
11	Хүү торгуулийн орлого	65.50	68.88	3.38	105.2%
12	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	11.60	12.94	1.34	111.5%
13	Цалин хөлс түүнтэй адилтгах хөрөнгө	207.00	215.57	8.57	104.1%
	НИЙТ	491.50	511.81	20.30	104.1%

Эх сурвалж: Айраг сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт 11 нэр төрлийн орлого 20.7 сая төгрөгөөр давж, 2 нэр төрлийн орлого 0.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлого давж биелсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Цалин хөлс түүнтэй адилтгах орлого төлөвлөсөн дүнгээс 8.6 сая төгрөгөөр давсан нь албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Хадгаламжийн хүүгийн орлого 0.9 сая төгрөгөөр давсан нь Төрийн банкны хадгаламжийн хүүгийн орлого сумын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.
- Хөрөнгө борлуулсны орлого 0.3 сая төгрөгөөр давсан нь үл хөдлөх хөрөнгийн борлуулалт, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой.
- Малын тоо толгойн албан татварын орлого 5.0 сая төгрөгөөр давсан нь малын тоо толгойн өсөлтөөс шалтгаалсан байна.
- Улсын тэмдэгтийн хураамжийн орлого 0.4 сая төгрөгөөр давсан нь газрын дуудлага худалдаа болон тамхины тусгай зөвшөөрөл сунгалттай холбоотой байна.
- Газрын төлбөр 0.6 сая төгрөгөөр давсан нь уул уурхайн компаниудын төлбөр барагдсантай холбоотой байна.
- Хүү торгуулийн орлого 3.4 сая төгрөгөөр давсан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалсан байна.
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 1.3 сая төгрөгөөр давсан нь шинээр ногдуулсан болон ААНБ-ын татварыг барагдуулсантай холбоотой байна.

Орон нутгийн орлого дараах шалтгааны улмаас тасарсан байна. Үүнд:

- Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 0.3 сая төгрөгөөр тасарсан нь ХХОАТ-ын тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотой байна.

3.5.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын 2021 оны 04/04 дүгээр тогтоолоор 1,621.0 сая төгрөгийн төсвийг урсгал зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 234.9 сая төгрөгийг аймгаас авах татаас санхүүжилтээс, 415.8 сая төгрөгийг сумын татварын болон татварын бус орлогоос, 336.7 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 551.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс, 82.2 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,621.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Тайлант онд төсөвт нэг удаа тодотгол хийсэн бөгөөд сумын ИТХ-ын 2022 оны 07/02 дугаар тогтоолоор 66.1 сая төгрөгөөр бууруулж 1,554.9 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор аймгаас авах татаас санхүүжилтийг 144.9 сая төгрөгөөр бууруулж, сумын татварын болон татварын бус орлогыг 78.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсөв зарцуулах эрхийг 1,554.9 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр сумын татварын болон татварын бус орлого 511.8 сая төгрөг, аймгаас авсан татаас санхүүжилт 59.2 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 551.4 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 95.2 сая төгрөг нийт 1,217.6 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,294.8 сая төгрөг буюу 83.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагаа зардлын төсвийг 187.6 сая төгрөгөөр, ОНХС-ийн зардлыг 69.5 сая төгрөгөөр, баг хорооны үйл ажиллагааны зардлыг 2.4 сая төгрөгөөр, багийн ИНХ-ын даргын урамшуулал зардлыг 0.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	712.30	524.70	187.60	73.7%
2	Баг, хорооны ҮАЗардал	62.50	60.10	2.40	96.2%
3	Мэдээлэл, сурталчилгааны зардал	2.70	2.70	0.00	100.0%
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	0.50	0.50	0.00	100.0%
5	Орон нутгийн нөөц хөрөнгө	10.00	10.00	0.00	100.0%
6	Хур хог хаягдал, орчны бохирдол	17.10	17.10	0.00	100.0%
7	Улсын их баяр наадам	5.00	5.00	0.00	100.0%
8	Багийн ИНХ-ын даргын урамшуулал	1.20	0.60	0.60	50.0%
9	Гэмт хэргээс урьдчилан сэргийл	4.80	4.80	0.00	100.0%
10	ОНХС – Бусад хөрөнгө оруулалт	738.80	669.30	69.50	90.6%
	Дүн	1,554.90	1,294.80	260.10	83.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 05/04 дүгээр тогтоолоор сумын Эрүүл мэндийн төв, Сургууль, Цэцэрлэг, Соёлын байгууллагуудын үйлчилгээ ашиглалтын зардлыг 465.4 сая төгрөгөөр, зардлын санхүүжилт 465.4 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгохоор тус тус баталсан байна.

Хүснэгт 12. Орон нутгийн өмчийн үйлчилгээ ашиглалтын зардлын санхүүжилтийн хуваарилалт, төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Байгууллага	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Соёлын төв	84.80	83.99	0.81	99.0%
2	ЭМТөв	58.10	49.86	8.25	85.8%
3	Сургууль	255.18	252.61	2.57	99.0%
4	Цэцэрлэг	67.36	64.84	2.52	96.3%
	Дүн	465.44	451.31	14.14	97.0%

Гүйцэтгэлээр 296.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгон, цалингийн зардалд 49.9 сая төгрөг, АОНДТШ-ийн зардалд 6.2 сая төгрөг, тогтмол зардалд 377.6 сая төгрөг, урсгал засварын зардалд 17.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 13. Орон нутгийн өмчийн үйлчилгээ ашиглалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49.9	49.9	0
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6.2	6.2	0
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	385.8	377.6	8.2
4	Урсгал засварын зардал	23.5	17.6	5.9
	Нийт	304.5	296.5	8.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал- Олон нийтийн цагдаагийн урамшуулал 5.7 сая төгрөгийг БГАҮТХ зардлаас /210801/ зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5-д төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах заалтыг зөрчиж 0.5 сая төгрөгийн мөнгөн аяга худалдан авч малчдад хүндэтгэл үзүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумын Засаг даргын тамгын газар – Цалингийн зардлаас 0.5 сая төгрөгийг бараа материалын зардалд буруу бүртгэсэн алдааг аудитын явцад залруулав.

Сумын Засаг даргын тамгын газар – Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.1 "гар утасны зардал", 12.1.3 "хэвлэлийн захиалгын төлбөр", 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" заалтуудыг зөрчин 1.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан - Өмнөх оны авлага Од жи Од ХХК-с буцаалт 18.0 сая төгрөгийн авлага барагдсаныг тайланд үеийн орлогоор хүлээн зөвшөөрсөн алдааг аудитын явцад залруулав.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан – Тайлант онд олгосон санхүүжилт 669.3 сая төгрөг болон өмнөх оны дуусаагүй барилга дансны 62.6 сая төгрөгийн, тайлант оны 12.9 төгрөгийн зардлыг зөрүүтэй тайлагнасан алдааг аудитын явцад залруулав.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан – Завсрын аудитаар СИТХ-аар батлагдсан арга хэмжээг гүйцэтгэгч 9 ААНБ-руу нийт 296.4 сая төгрөгийн санхүүжилтийг цахим төлбөрийн баримтгүйгээр хийсэн зөрчилд зөвлөмж өгсөн.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсөвт байгууллагууд нь тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 23.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 34.1 сая төгрөг, нийт 57.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: хангамж, бараа материалын зардалд 6.6 сая төгрөг, томилолтын зардалд 0.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 27.6 сая төгрөг, нийт 34.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 23.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төсвийн үр ашигтай захиран зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах Б.Алтанзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Айраг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 02-ний өдрийн 0103/128 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 1 хувиар буюу 105.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Учир нь 2022 оноос улсын төсвийн санхүүжилтийн байгууллага болох эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын төсөв, санхүүгийн тайлан харьяа Төсвийн ерөнхий захирагчдаа шилжиж байгаатай холбоотойгоор 2021 оны санхүүгийн тайлангаар материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сонгох боломжгүй гэж үзлээ.

Гүйцэтгэлээр материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 4,320.9 сая төгрөгийн 1 хувь буюу 43.2 сая төгрөг, үүний 70 хувь болох 30.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш харьяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хэмнэлтийн горимуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 669.3 сая төгрөгийн худалдан авалтын санхүүжилтийг, өмч хөрөнгө зарцуулах 698.7 сая төгрөгийн 38 шийдвэрийг хугацаандаа, бүрэн мэдээлсэн байна.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд 5 горим сорил хэрэгжүүлж төлөвлөгөөг батлуулсан.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	-	1	-	100%
Нийт дүн	1	-	1	-	100%

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татсан асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага, сан түүврээр хамрагдсан байна.

Нөхөн сэргээлтийн тусгай дансны санхүүгийн тайланг аудит хийх байгууллагын тоонд оруулж, аудит хийх хуваарь батлуулаагүй ба ТТЗ-ийн санхүүгийн тайлангийн хугацаанд аудитад хамруулж, шалгасан болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд 1 байгууллагад “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	2	94.4	1	93.9	1	0.5	2	94.4				
Орон нутгийн хөгжлийн сан	3	36.0			3	36.0	3	36.0				
Дүн	5	130.4	1	93.9	4	36.5	5	130.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	2	6.2			1	5.7	1	0.5				
Засаг даргын тамгын газар	1	1.5					1	1.5				
Орон нутгийн хөгжлийн сан	1	-					1	-				
Дүн	4	7.7			1	5.7	3	2.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												